



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 12 өдөр

Дугаар A/637

Алтай хот

Р.Төмөрчөдөрт ажилгүй байсан
хугацааны олговор олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.7 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.2 дэх заалт, Дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдааны 2020 оны 001/ХТ2020/00386 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдааны 2020 оны 001/ХТ2020/00386 дугаар тогтоолын дагуу Засаг даргын хэвлэлийн төлөөлөгч Р.Төмөрчөдөрт ажилгүй байсан хугацааны олговрыг олгосугай.

2.Шаардагдах 3128920 (Гурван сая нэг зуун хорин найман мянга есөн зуун хорин) төгрөгийг аймгийн Засаг даргын нэмэлт санхүүжилтийн данснаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ч.Бат-Эрдэнэ)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Т.Энхцэцэг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ж.ГАНБАТ